

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

“Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний
дүүрэгт хамааралтай заалтын 2025 оны эхний хагас жилийн
хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийсэн тухай”

2025 оны 06 дугаар сарын 27

Улаанбаатар хот

Нэг. Хяналт- шинжилгээ хийх үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ыг үндэслэв.

Хоёр. Хяналт- шинжилгээний зорилго

Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнөөс дүүрэгт хамааралтай заалтуудын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэл үр дүнг нэмэгдүүлэх, холбогдох хууль тогтоомж, норм стандартын хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай санал зөвлөмжийг боловсруулахад оршино.

Гурав. Хяналт- шинжилгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын холбогдох заалтыг үндэслэн Нийслэлийн хөгжлийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд дараах хяналт-шинжилгээний аргачлалыг хэрэглэв.

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} * 100$$

Дөрөв. Хяналт- шинжилгээний үр дүн

Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнөөс дүүрэгт хамааралтай 15 ажил, арга хэмжээг хяналтад авч хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Хяналтад авсан 15 ажил, арга хэмжээг авч үзвэл

60-84 хувьтай "үр дүн хүлээгдэж байгаа" - 2

30-59 хувьтай "үр дүн хангалтгүй" - 9

0-29 хувьтай "үр дүн гараагүй" - 2

хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй – 2 ажил, арга хэмжээ байна.

Тав. Хяналт-шинжилгээний дүгнэлт

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг үндэслэн Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналтад авсан 15 ажил, арга хэмжээний 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд:

1. Тайлагнасан 15 ажил, арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 56,6 хувьтай буюу “Үр дүн хангалтгүй” гэж үнэлэгдэж байна.
2. 0-29 хувьтай үр дүн гараагүй 2 ажил, арга хэмжээ нь дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, дээд байгууллагаас хэрэгжүүлэхээр ажил, арга хэмжээ байна.

3. Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний дүүрэгт хэрэгжсэн арга хэмжээний хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 6.1-д заасан аргачлалаар тооцон гаргах боломжгүй. Учир нь Нийслэлийн хөгжлийн 2025 төлөвлөгөөнд тусгагдсан суурь түвшин, зорилтот түвшинг дүүргийн хэрэгжилт, түвшинтэй харьцуулах боломжгүй.
4. Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний дүүрэгт хамаарах заалтуудын хэрэгжилтийг тухайн ажил, арга хэмжээний хэрэгжилтийн явцаар хувийг тооцсон.

Зургаа. Цаашид анхаарах асуудал

1. Үр дүн хангалтгүй байгаа 9 ажил, арга хэмжээг эрчимжүүлж, ажиллах
2. Хэрэгжээгүй ажил, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодорхой тусгах
3. Төлөвлөгөөний биелэлтийг хэмжих нэгж, шалгуур үзүүлэлтийг хүрээнд тайлагнах
4. Тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, нотлох баримтыг хавсаргаж, тодорхой гаргах

Долоо. Зөвлөмж

1. Нэгжийн дарга нар Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд анхаарч, төлөвлөгөөт ажлуудаа хугацаанд нь хэрэгжүүлж, хариуцсан албан хаагчийг үүрэгжүүлэн хяналт тавьж ажиллах
2. Төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа үр дүнг тооцсон, тоо баримтыг нэгтгэсэн арга хэмжээг хэмжих, үнэлэх үндэслэлтэй хоёр мянган тэмдэгтэд багтаан хэрэгжилтийн явцыг товч тодорхой, нотлох баримтыг хавсаргасан байх

ХЯНАСАН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА  С.ТУУЛМАА

БОЛОВСРУУЛСАН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН  О.ЯНЖИНЛХАМ